



МОНГОЛ УЛС  
ТӨВ АЙМГИЙН БОРНУУР СУМЫН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
IX -Р ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2021 оны 06 сарын 30 өдөр

Дугаар 07

Борнуур

Хоршоо хөгжүүлэх сангийн тухай

Монгол Улсын “Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 31 дүгээр зүйлийн 35.1.9, Хүнс Хөдөө аж ахуй Хөнгөн Үйлдвэрийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 13 – ны өдрийн А/361 дугаар тушаалаар батлагдсан “Хоршоо хөгжүүлэх сангаас хөнгөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам” – ын 2.7, 3.3.1, 3.3.2, 3.3.3, 3.3.4, 4 дүгээр зүйлийн 4.1, 4.2, 4.3, 4.4 дэх заалт, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 18 – ны өдрийн 05 тоот тогтоол, Аймгийн засаг аргын 2022 оны 02 дугаар сарын 17 – ны өдрийн А/94 тоот захирамжийг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Хоршоо хөгжүүлэх сангийн 2021 оны 12 дугаар сарын 31- ны эцсийн үлдэгдэл 317518875 төгрөгийг 2022 оны эх үүсвэрээр 2022 онд олгох зээлийн хэмжээг 100 000 000 төгрөгөөр тус тус баталсугай.

2. 2021 онд олгосон зээлийн нэг жилийн хүү болох 6 187 614 төгрөгийн 30 хувийг зээлдэгчдэд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх сургалтанд, 20 хувийг төслийн хэрэгжилтийн явц үр дүн, эргэн төлөлтөд хяналт тавих, хэрэгжилтийг хангуулах ажилд 10 хувийг сан хариуцсан мэргэжилтэний урамшуулалд улирал бүр зарцуулахыг /Н.Ундрахбилэг / - т зөвшөөрсүгэй.

3. 2022 онд олгох зээлийн тэргүүлэх чиглэлийг нэгдүгээр, Төсөл сонгон шалгаруулах хорооны бүрэлдэхүүнийг хоёрдугаар, Хяналтын зөвлөлийн бүрэлдэхүүнийг гуравдугаар хавсралтаар баталсугай.

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 07 дугаар сарын 30 – ны өдрийн VI хуралдааны 05, 06, 07 дугаар тогтоол, 2021 оны 12 дугаар сарын 18 – ны өдрийн VII хуралдааны 05 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт, 06 тогтоолуудыг тус тус хүчингүйд тооцсугай.

5. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын /Төсөв санхүү, эдийн засгийн хөгжлийн хороо / - д даалгасугай.



ДАРГА

Ц.НАРАНГЭРЭЛ

00900014

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны  
дугаар сарын 20 ны өдрийн 18 хуралдааны  
тоот тогтоолын хавсралт1



## 2022 ОНД ОЛГОХ ЗЭЭЛИЙН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ

- Өсвөр үхрийн аж ахуй
- Сүүний фермийн аж ахуй
- Сүү боловсруулах жижиг үйлдвэр
- Түүхий эдийн анхан шатны боловсруулалт
- Хүлэмжийн аж ахуй
- Зөгийн аж ахуй
- Хүнсний ногоо боловсруулалт
- Ногооны агуулах зоорь
- Ойн хаягдал, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн хаягдал дахин боловсруулалт
- Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл
- Боловсруулах чиглэлийн ЖДҮ, цехийг шинээр байгуулах, өргөжүүлэх
- Хоёрдогч түүхий эдийн цэг байгуулах
- Барилгын ханын болон бусад материал үйлдвэрлэлийг дэмжих

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны  
... сугаар сарын 30 ны өдрийн ... хуралдааны  
... тоот тогтоолын хавсралт 2



**ХОРШОО ХӨГЖҮҮЛЭХ САНГИЙН ЗЭЭЛИЙН ТӨСӨЛ  
СОНГОН ШАЛГАРУУЛАХ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН**

Зээлийн хороон дарга: сумын Засаг даргын Тамгын газрын дарга

Эр

Нарийн бичгийн дарга: Сумын ЗДТГ - ын хүнс, жижиг дунд үйлдвэр хариуцсан  
мэргэжилтэн

Эр

Гишүүд: Хоршоо хөгжүүлэх сангийн нягтлан бодогч

Эр


Төрийн бус байгууллагын төлөөлөл - Б.Атартунгалаг

Эм

Төрийн бус байгууллагын төлөөлөл - Д.Оргилмаа

Эм

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны  
дугаар сарын 28 ны өдрийн 12 хуралдааны  
тоот тогтоолын хавсралт3



## ХОРШОО ХӨГЖҮҮЛЭХ САНГИЙН ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Хяналтын зөвлөлийн дарга: Аймаг, сумын ИТХ - ын Төлөөлөгч - Т.Должмаа

Нарийн бичгийн дарга: Сумын ЗДТГ – ын хүнс, жижиг дунд үйлдвэр хариуцсан  
мэргэжилтэн

Гишүүд: сумын ЗДТГ – ын Төрийн сангийн мэргэжилтэн

Аймгийн ХХААГ - ын жижиг дунд үйлдвэр хүнс хариуцсан мэргэжилтэн

Төрийн бус байгууллагын төлөөлөл - Б.Наранцогт